



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/623

Улаанбаатар хот

МУИС-ийн ажилтанд цалингийн
нэмэгдэл олгох журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь заалт, МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталж, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

2. Тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.12, 22.4, 22.5 дахь заалт, МУИС-ийн Захирал (ректор)-ын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/42 дугаар “Мэргэжлийн зэргийн болон ур чадварын нэмэгдэл олгох тухай” тушаал, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б.Даваасүрэн), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (С.Должин) нарт үүрэг болгосугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

- 1424054618

Ректорын 2024 оны 12 дугаар сарын 06-ны
өдрийн А/625 дугаар тушаалын хавсралт



МУИС-ИЙН АЖИЛТАНД ЦАЛИНГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын их сургуулийн удирдах, гүйцэтгэх, үйлчилгээний ажилтанд эрдмийн зэрэг, цол, мэргэшлийн зэрэг, ур чадвар (албан тушаал) болон хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг тооцож олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Удирдах, гүйцэтгэх болон үйлчилгээний ажилтны цалингийн нэмэгдлийг тооцож олгохдоо мэргэшсэн, тогтвортой байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 2.1.1. “Ажилтан” гэж МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1.2-т зааснаар ойлгоно;
- 2.1.2. “Нэмэгдэл” гэж эрдмийн зэрэг, цол, мэргэшлийн зэрэг, ур чадвар (албан тушаал), хөдөлмөрийн нөхцөл зэргийг харгалзан олгох нэмэгдлийг;
- 2.1.3. “Эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл” гэж тухайн албан тушаалыг өндөр мэдлэгтэй, мэргэшсэн хүний нөөцөөр бэхжүүлэх, ажилтан эрдэм мэдлэгээ дээшлүүлж байх сонирхлыг дэмжих зорилгоор олгох нэмэгдлийг;
- 2.1.4. “Мэргэшлийн зэргийн нэмэгдэл” гэж тухайн албан тушаалыг мэргэшсэн хүний нөөцөөр бэхжүүлэх, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэхийг дэмжин олгох нэмэгдлийг;
- 2.1.5. “Ур чадвар (албан тушаал)-ын нэмэгдэл” гэж тухайн ажилтны ажил гүйцэтгэх ур чадвар, арга барил, идэвх санаачилгыг нь дэмжих зорилгоор олгох нэмэгдлийг;
- 2.1.6. “Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл” гэж ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг харгалзан олгож байгаа нэмэгдлийг.

Гурав. Цалингийн нэмэгдэл олгох

3.1. Эрдмийн зэрэг, цолны нэмэгдлийг Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”-ын дагуу олгоно¹.

¹ Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

3.2. Ажилтан тухайн салбарын хууль тогтоомжийн дагуу мэргэшсэн байх шаардлагыг хангаж, эрх бүхий байгууллагаас олгосон мэргэшлийн үнэмлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай гэрчилгээтэй тохиолдолд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгоно.

3.3. Мэргэшлийн зэрэг олгох албан тушаал, нэмэгдлийн хэмжээг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар тооцож олгоно:

- 3.3.1. Нягтлан бодогчоор ажиллаж байгаа ажилтан “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт”-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орж мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан бол 15 хувь²;
- 3.3.2. Архив, бичиг хэргийн ажилтан, захирлын туслах “Архивын ерөнхий газар”-аас зохион байгуулсан албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны сургалтад суралцаж, мэргэжлийн үнэмлэх авсан эсхүл ахлах зэрэгтэй бол 10 хувь, тэргүүлэх зэрэгтэй бол 15 хувь, зөвлөх зэрэгтэй бол 20 хувь³;
- 3.3.3. Барилгын инженерээр ажиллаж байгаа ажилтан нь мэргэшсэн төсөвчин бол 10 хувь⁴;
- 3.3.4. МУИС-ийн эмнэлгийн сувилагч ахлах зэрэгтэй бол 10 хувь, тэргүүлэх зэрэгтэй бол 15 хувь, зөвлөх зэрэгтэй бол 20 хувь⁵;
- 3.3.5. Дотоод аудиторын албан тушаалд ажиллаж байгаа ажилтан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдаж дотоод аудиторын мэргэшлийн гэрчилгээ авсан бол 15 хувь.

3.4. Мэргэшлийн зэргийн хугацаа дууссан, хүчингүй болсон, тухайн чиглэлээрээ ажиллаагүй тохиолдолд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгохгүй.

3.5. Шинээр ажилд орсон ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг туршилтын хугацаанд олгохгүй.

3.6. Ур чадвар (албан тушаал)-ын нэмэгдлийг дараах тохиолдолд олгоно:

- 3.6.1. МУИС-ийн цалингийн сүлжээгээр УАТ албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг хангасан ажилтны ур чадвар (албан тушаал)-ын нэмэгдлийг 15 хувиар тооцож олгоно;
- 3.6.2. Хөрөнгө оруулалт татах үр дүнгийн гэрээ байгуулан ажиллах ажилтны ур чадварын нэмэгдлийг 10 хувиар тооцох ба цаашид бодитой, мөнгөн дүнгээр хэмжигдэхүйц хөрөнгө оруулалт татсан тохиолдолд ур чадварын нэмэгдлийг үргэлжлүүлэн олгоно.

3.7. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ нь тухайн ажилтны албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцүү байна.

Дөрөв. Бусад

4.1. Цалингийн нэмэгдэл олгох зардлыг байгууллагын жилийн төсөвт тусгана.

² Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1

³ Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт


⁴ Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралт

⁵ Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

4.2. Ажилтан цалингийн нэмэгдэл олгох хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд хоёроос илүү нэмэгдэл олгохгүй.

4.3. Хүний нөөц болон санхүүгийн асуудал хариуцсан нэгж журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

4.4. Ажилтан ажлын зайлшгүй шаардлагаар нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсэн, ажил олгогчтой тохиролцсоноор ажил хослон гүйцэтгэсэн, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, албан тушаал хавсран гүйцэтгэсэн, ажлын ачааллыг нэмэгдүүлж ажилласан тохиолдолд олгох цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулна.



---oOo---